



## АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

### I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан  
огноо:

Байгууллагын нэр:

Эрүүл мэндийн газар

Нэгжийн нэр:

Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс

Албан тушаалын нэр:

Эрүүл мэндийн боловсрол, сургалт  
сурталчилгаа, гадаад харилцаа  
хариуцсан мэргэжилтэн

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Дэс түшмэл, ТЗ-5

Ажлын цаг:

Ажлын өдрийн 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын 1 дүгээр  
баг, Дэмид жанжин 100-1.

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

### II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:


Эрүүл мэндийн салбарын хууль тогтоомж, бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих, арга зүйн дэмжлэг үзүүлэх, хүн амд эрүүл, зөв аж төрөх дадлыг төлөвшүүлэх, эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлэх чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1. Эрүүл мэндийн салбарын хууль тогтоомж, бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, нэгдсэн удирдлагаар хангах, хянах, тайлагнах;
2. Эрүүл мэндийг дэмжих орчинг бүрдүүлэх, мэдээлэл сургалт сурталчилгааг эрчимжүүлэх, архи, тамхи, мансууруулах бодисын эрсдэлт зан үйлийг өөрчлөхөд чиглүүлэн үйлчилгээ үзүүлэх, мэргэжил арга зүйгээр хангах;
3. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг, дүрэм журам, стандартыг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1. Монгол Улсын хууль, тогтоомж, бодлого, тогтоол шийдвэр эрх зүйн акт, дүрэм, заавар, стандарт, удирдамжийг мөрдлөг болгон ажиллах; 2. Хууль тогтоомж, бодлого, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх, тайлагнах; 3. Харъяа нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага, иргэд аж ахуйн нэгжийгэрүүл мэндийг дэмжих орчинг бүрдүүлэх, мэдээлэл сургалт сурталчилгааг эрчимжүүлэх, архи, тамхи, мансууруулах бодисын эрсдэлт зан үйлийг өөрчлөх чиглэлээр мэргэжлийн удирдлага, үйл ажиллагааны нэгдсэн бодлого чиглэлээр хангаж ажиллах;	Хэрэгжилтийн хувь  Хэрэгжилтийн хувь.  Нэгдсэн бодлого, чиглэлийг хангасан эсэх	Г, Х,  Г,Х  Г,Х
2 дугаар зорилтын хүрээнд	1. Нийгмийн эрүүл мэндийн мэдээлэл сургалт, сурталчилгааны талаар аймгийн эрүүл мэндийн байгууллага, бусад төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагуудын удирдлага, ажилтнуудад сургалт явуулах, мэдээлэл, арга зүйгээр хангаж ажиллах; 2. Хүн амын эрүүл мэндийн мэдлэг, хандлага, дадлын өнөөгийн байдалд үнэлгээ өгч, тэдний хэрэгцээ шаардлагыг нас, хүйс, мэргэжил, ахуй амьдрал, эрүүл мэндийн байдалтай нь холбон судлах ажлыг зохион байгуулж, мэдээлэл, сургалт, сурталчилгааны	Арга зүйгээр хангасан эсэх  Сургалтын үнэлгээний ахиц	Г  Г, Т

<p>мэндийн сургалтын агуулга, арга зүйг боловсруулж тусгай хөтөлбөрийн дагуу МСС-ны төрөл бүрийн арга хэмжээг дангаар болон хамтран зохион байгуулах;</p> <p>3. Хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх ажлыг мэдээлэл, сургалт, сурталчилгааны орчин үеийн шинэлэг арга барилаар явуулах арга зүйд эмч, сувилагч, эрүүл мэндийн бусад мэргэжилтнүүдийг сургах ажлыг зохион байгуулах;</p> <p>4. Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх мэдээлэл сургалт, сурталчилгааны талаар орон нутагт хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хянах, тайлагнах ажлыг хариуцан зохион байгуулах;</p> <p>5. Нийгмийн эрүүл мэндийн мэдээлэл, сургалт сурталчилгааны талаар мэдээллийн сан байгуулах, баяжуулах ажлыг зохион байгуулах;</p> <p>6. Эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг сургууль, цэцэрлэг, албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэд, эрүүл мэндийн байгууллагуудад өрнүүлэх талаар байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлага, ажилтнууд, иргэдэд зориулсан ухуулга, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах, эрүүл аймаг, сум, баг, байгууллага, сургууль, цэцэрлэг, иргэнийг хэрхэн бий болгох арга зүйгээр хангаж ажиллах;</p> <p>7. Эрүүл мэндийг дэмжигч сум, баг, байгууллага, хамт олон, гэр бүл, иргэнийг дэмжих үйл ажиллагааг өрнүүлэн мэргэжлийн арга зүйгээр хангаж ажиллах;</p> <p>8. Эрүүл мэндийг дэмжигч сум, баг, байгууллага, гэр бүл, иргэний туршлагыг аймгийн хэмжээнд түгээн өргөжүүлэхэд чиглэсэн төрөл бүрийн арга хэмжээ /уулзалт, зөвлөгөөн, уралдаан, тэмцээн, үзүүлэх сургууль, үзэсгэлэн, туршлага судлах аялал гэх мэт/ зохион байгуулах;</p> <p>9. Эрүүл мэндийг дэмжих, эрүүл мэндийн мэдээлэл, сургалт сурталчилгааны асуудлаар олон улсын байгууллага, өөрийн орны болон гадаад орны төрийн болон төрийн бус</p>	<p>Хамрагдалтын хувь</p> <p>Хэрэгжилтийн хувь</p> <p>Сан бүрдүүлсэн эсэх</p> <p>Арга зүйгээр хангасан эсэх</p> <p>Арга зүйгээр хангасан эсэх</p> <p>Оролцогчдын тоо нэмэгдсэн эсэх</p> <p>Хамтын ажиллагаа нэмэгдсэн эсэх</p> <p>Хэрэгжилтийн хувь</p>	<p>Г, Х, Т</p> <p>Г</p> <p>Г</p> <p>Г</p> <p>Г</p> <p>Г</p> <p>Г</p> <p>Г, Т</p> <p>Г</p>
--	--	---



<p>байгууллага, аж ахуй нэгж, гэр бүл, иргэд, хамт олны үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хамтран ажиллах;</p>	Хэрэгжилтийн хувь	Г
<p>10. Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд болон төрийн болон төрийн бус байгууллагуудыг эрүүл мэндийг дэмжих, нийгмийн эрүүл мэндийн сургалт, сурталчилгааны ажилд татан оролцуулах, энэ талаар хамтарсан төлөвлөгөө гаргах гэрээ байгуулах зэргээр ажиллах;</p>	Хэрэгжилтийн хувь	Г
<p>11. Нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөр, төсөл, стратегийг хэрэгжүүлэхэд чиглэсэн мэдээлэл сургалт сурталчилгааны ажлыг арга зүйгээр хангаж хамтарч ажиллах;</p>	Хэрэгжилтийн хувь	Г
<p>12. Архи, тамхи мансууруулах бодисын хэрэглээг хянах, бууруулах талаар хэрэгжиж байгаа хууль, үндэсний хөтөлбөр, стратегийн хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд зохион байгуулах, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах, хэрэгжилтийг хянах, тайлагнах;</p>	Хэрэгжилтийн хувь	Г
<p>13. Архи, тамхи мансууруулах бодисын хэрэглээг бууруулах талаар орон нутгийн онцлогт нийцсэн бодлого, арга хэмжээг төлөвлөх, батлуулах, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд эрүүл мэндийн болон бусад холбогдох салбарын мэргэжилтнүүдийг оролцуулах, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах, хэрэгжилтийг хянах, тайлагнах;</p>	Хэрэгжилтийн хувь	Г
<p>14. Архи, тамхи, мансууруулах бодисын хэрэглээ, тэдгээрт нөлөөлөх хүчин зүйлийн талаар судалгаа хийх, судалгааны дүнд үндэслэн</p>	Хэрэгжилтийн хувь	Г
<p>шаардлагатай арга хэмжээг төлөвлөн авч хэрэгжүүлэх, арга зүйгээр хангах;</p> <p>15. Архи, тамхи, мансууруулах бодисын</p>	Хэрэгжилтийн хувь	Г

<p>тусламж үйлчилгээг нэвтрүүлэх талаар эмч сувилагч нарын чадавхийг дээшлүүлэх, энэ ажилд мэргэжлийн байгууллагуудын дэмжлэгийг авч ажиллах;</p>	<p>Арга зүйгээр хангасан эсэх</p>	<p>Г</p>
<p>17. Нэгдсэн эмнэлгийн түвшинд үзүүлж буй наркологи тусламжийн чанар, хүртээмжийг сайжруулах үйл ажиллагааг зохион байгуулах;</p>	<p>Мэдээллээр хангасан эсэх</p>	<p>Г</p>
<p>18. Наркологийн чиглэлээр анхдагч болон хоёрдогч шатлалын ЭМБ-ын үйл ажиллагааны уялдаа зохицуулалтыг сайжруулах арга хэмжээ авах;</p>	<p>Хэрэгжилтийн хувь</p>	<p>Г</p>
<p>19. Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг архи, тамхи, мансууруулах эм, бодис хэрэглэдэг үйлчлүүлэгчтэй ажиллах арга барилд сургаж, мэдлэг мэргэжлийг нь байнга дээшлүүлэх ажлыг мэргэжлийн байгууллага, мэргэжилтэнтэй хамтран зохион байгуулах, үр дүнг тооцох;</p>	<p>Хэрэгжилтийн хувь</p>	<p>Г</p>
<p>20. Архи, тамхи, мансууруулах эм, бодисын хор хөнөөлийн талаар явуулах мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг эрүүл мэндийн тусламж үйлчилгээний шатлал бүрд зохион байгуулах ажлыг мэргэжил аргазүйгээр хангаж ажиллах;</p>	<p>Хэрэгжилтийн хувь</p>	<p>Г</p>
<p>21. Архи, тамхи, мансууруулах эм, бодисын хор хөнөөлийн талаар олон нийтэд зориулсан гарын авлага, сургалт, сурталчилгааны материал боловсруулж /олшруулж, холбогдох</p>	<p>Хэрэгжилтийн хувь</p>	<p>Г</p>
<p>мэргэжилтнүүдийг мэдээллээр хангах;</p> <p>22. Архи, тамхи, мансууруулах бодис хэрэглэх эрсдэлтэй зан үйлийг өөрчлөх, архи, тамхигүй эрүүл мэндийг дэмжсэн орчин бүрдүүлэх талаар эрүүл мэндийн болон бусад салбарын байгууллага, мэргэжилтэнтэй хамтран ажиллах, тайлагнах;</p>	<p>Хэрэгжилтийн хувь</p>	<p>Г</p>
<p>23. Архи, тамхи, мансууруулах эм, бодисын хэрэглээг бууруулахад чиглэсэн арга хэмжээнд иргэд, олон нийт, төрийн бус байгууллагыг татан оролцуулах, арга зүйгээр хангах, идэвхжүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх;</p>	<p>Дэмжлэг үзүүлсэн эсэх</p>	<p>Г</p>
<p>24. Архи, тамхигүй орчин бий болгох үүсгэл санаачлагыг өрнүүлэх талаар байгууллага, хамт олон, гэр бүлийг идэвхжүүлэх, мэдээлэл, арга зүйгээр</p>		



	идэвхжүүлэх, мэдээлэл, арга зүйгээр хангаж ажиллах, үр дүнг тооцох; 25. Архи, тамхи, мансууруулах бодисын хор хөнөөлийн талаар явуулах МСС-ны ажлыг дангаар болон бусад холбогдох мэргэжилтэнтэй хамтран зохион байгуулах; 26. Архины асуудалтай хүмүүсийн "АА" цуглааны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх.		
3 дугаар зорилтын хүрээнд	1. Төрийн албаны стандарт, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг мөрдөж ажиллах; 2. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх; 3. Архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, стандартыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах; 4. Удирдлагын хуульд нийцсэн үүрэг даалгаврыг гүйцэтгэх, эргэн мэдээлэх; 5. Байгууллага, нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, биелэлтийг тайлагнах; 6. Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж хэрэгжүүлэх, биелэлтийг тайлагнах; 7. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.	Ёс зүйн зөрчил гаргасан эсэх  Ашиг сонирхлын зөрчилгүй гаргасан эсэх  Хэрэгжилтийн хувь  Биелэлтийн хувь  Хэрэгжилтийн хувь  Хэрэгжилтийн хувь  Хэрэгжилтийн хувь	Г  Г  Г  Г  Г  Г

### III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй	
Мэргэжил	Анагаах ухаан /0912/, нийгмийн эрүүл мэнд /091801/, Гадаад хэл, орон судлал /023102/, Олон улсын харилцаа /022204/,	
Мэргэшил	Төрийн албаны мэргэшүүлэх богино, дунд хугацааны сургалтад хамрагдаж төгссөн байх.	
Туршлага	Төрийн албанд 2-оос доошгүй жил ажилласан байх.	
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	- Судалгааны арга зүйн мэдлэгтэй байх; - Албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл цуглуулах, боловсруулах, харьцуулалт хийх; - Нэгтгэж дүгнэх, санал, зөвлөмж боловсруулах; - Гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; - Бусад.
	Асуудал шийдвэрлэх	- Үндэсний язгуур эрх ашиг, сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж төрд үнэнчээр зүтгэх; - Хууль тогтоомжийн хүрээнд асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулах; - Шинэчлэл өөрчлөлт хийхийг зорьдог байх; - Өөрийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавьж чаддаг

		<p>харах чадвартай байх;</p> <ul style="list-style-type: none"> <li>- Хууль эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө өгөх чадвартай байх;</li> <li>- Бүтээлч, санаачилгатай ажиллах;</li> <li>- Бусад.</li> </ul>
	Багаар ажиллах	<ul style="list-style-type: none"> <li>- Өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж, бие биеэ дэмждэг байх;</li> <li>- Багийн хамт олны дунд хүлээсэн үүргээ гүйцэтгэх;</li> <li>- Багийн зорилго, үйл ажиллагааг ойлгож, дасан зохицож ажиллах;</li> <li>- Үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах;</li> <li>- Хамт олонч сэтгэлгээтэй, эерэг уур амьсгалыг дэмждэг байх;</li> <li>- Нээлттэй, шударга байх;</li> <li>- Бусад.</li> </ul>
	Бусад	<ul style="list-style-type: none"> <li>- Өргөн цар хүрээтэй сэтгэж, үлгэрлэн манлайлдаг байх;</li> <li>- Зарчимч, тууштай, ажил хэрэгч байх;</li> <li>- Шинэ санал, санаачилга, бүтээлч хандлагатай байх;</li> <li>- Хувийн зохион байгуулалт, цаг ашиглалт сайтай байх;</li> <li>- Албан ажлын чиг үүргийнхээ дагуу зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллах чадвартай байх;</li> <li>- Компьютерийн хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах;</li> <li>- Төрийн албан хэрэг хөтлөлт, бичиг хэрэг, монгол хэл, найруулгын чадвартай байх;</li> <li>- Англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах чадвартай байх.</li> </ul>

#### IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга

<p>Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:</p> <p>Байхгүй</p>	<p>Бусад харилцах субъект:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Эрүүл мэндийн байгууллагуудын дарга нар;</li> <li>- Нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын холбогдох ажилтан;</li> <li>- Эрүүл мэндийн яамны холбогдох мэргэжилтэнүүд;</li> <li>- Эрүүл мэндийн хөгжлийн төвийн холбогдох мэргэжилтэнүүд;</li> <li>- Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийн холбогдох мэргэжилтэнүүд;</li> <li>- Иргэн, хуулийн этгээд, төрийн бус байгууллагын холбогдох ажилтан.</li> </ul>
--	---

#### V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

<p>Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:</p>	<p>Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:</p>
<p>Албан тушаал: УДИРДЛАГА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮУ,</p>	<p>Байгууллагын нэр:</p>

<p>ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, МЭДЭЭЛЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Б.АЗЖАРГАЛ 20... оны ... дугаар сарын ... -ны өдөр</p>	<p>ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ Шийдвэрийн огноо: <b>19 10 30</b> Дугаар: <b>181</b>...</p>
--	---

**Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:**

Байгууллагын нэр:  
АРХАНГАЙ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР

Шийдвэрийн огноо: *2019.12.26*.....

Дугаар: *1159*.....

(тамга/тэмдэг)

ДАРГА *Р. Гандиймаа* Р.ГАНДИЙМАА

20... оны ... дугаар сарын ... -ны өдөр



-----oOo-----